

---

**Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших  
“Хүнд даацын машин механизмын засварын төв”-ийн  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

---

**“БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК**

## Гарчиг

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	5
	2.1.1 Судалгааны талбайн байршил .....	5
	2.1.2 Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл.....	6
	2.1.3 Геологийн тогтоц ба геоморфологи .....	6
	2.1.4 Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар.....	7
	2.1.5 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол.....	7
	2.1.6 Ургамлан бүрхэвч .....	9
	2.1.7 Амьтны аймаг.....	9
	2.1.8 Тусгай хамгаалалттай газар .....	11
	2.1.9 Нийгэм-эдийн засгийн нөхцөл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3	ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	13
4	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	15
	4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	16
	4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....	18
	4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	19
	4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	22
	4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	<b>Error! Bookmark not defined.</b>
	4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь .....	24
5	ДҮГНЭЛТ .....	26

### Зургийн жагсаалт

Зураг 1. Засварын цехийн төлөвлөлтийн зураг .....	3
Зураг 2. Засвар үйлчилгээний барилга болон ажилчдын байр .....	4
Зураг 3. Хүнд машин механизмын задгай агуулах.....	4
Зураг 4. Төслийн талбайн байршил, сансрын зураг .....	5
Зураг 5. Зүсэлт хийсэн талбайн орчны төрх болон хөрсний зүсэлтийн зураг	8
Зураг 6. Судалгааны талбай болон тусгай хамгаалалттай газар нутгийн байршил .....	11
Зураг 7. Судалгааны талбайн барилга, байгууламж .....	13

### Хүснэгтийн жагсаалт


Хүснэгт 1. 0006411 газар ашиглах гэрчилгээтэй талбайн солбицол .....	5
Хүснэгт 2. Өмнөговь аймаг дахь улсын тусгай хамгаалалттай газар нутгууд .....	11
Хүснэгт 3. Номгон багийн хүн ам, мал аж ахуйн зарим үзүүлэлтүүд, 2018 он .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Хүснэгт 4. Байгаль орчны шинжилгээ.....	14
Хүснэгт 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал .	25

## 1 ТЭСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Засвар, техник үйлчилгээний хэсэгт 1 хоногт 2 машин, 7 хоногт 10 тээврийн хэрэгсэл болон хүнд машин механизмд хөдөлгүүрийн тос солих, явах эд ангийн засвар, хөдөлгүүрийн засвар, оношилгоо ба бусад үйлчилгээг үзүүлдэг.

Тус төслийн үндсэн зорилго нь Оюутолгой болон тухайн бүсэд хэрэгжиж байгаа хүнд даацын машин, механизмын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх зорилготой юм.

Тус засвар, үйлчилгээний цех нь нийт 3485 м<sup>2</sup> талбайд төлөвлөгдсөн бөгөөд энд тоног төхөөрөмжийн оношилгоо, засвар үйлчилгээ, техникийн тос, тосолгоо, задлах, засварлах, угсрах үйл ажиллагаа явагдана.



Зураг 1. Засварын цехийн төлөвлөлтийн зураг

Эдэлбэр газрын баруун талд засвар үйлчилгээний цехийн барилга, түүний хойд талд залгаа ажилчдын кемп байрлана. Зүүн талд хүнд машин механизмын задгай талбайд байрлана.



*Зураг 2. Засвар үйлчилгээний барилга болон ажилчдын байр*



*Зураг 3. Хүнд машин механизмын задгай агуулах*

Засвар үйлчилгээний агуулахын 2 давхарт оффис, 1 давхарт хүнд даацын машин механизмын сэлбэг хэрэгсэл хадгалах агуулах, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байрлана.

**Эрчим хүч:** Цахилгаан эрчим хүчний хэрэглээг өөрийн дизель цахилгаан эх үүсвэрээс хангадаг.

**Усны хэрэглээ:** Ус хэрэглээний нийт хэмжээ 1 хоногт  $15.01\text{м}^3$  буюу  $0.17$  л/с байна. Энэхүү усны хэрэглээг 60 м гүнтэй, усны тогтсон түвшин 7.4 м, ашиглах боломжит ундарга 1.2 л/с-тэй худгаас хангана.

## 2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ


### 2.1.1 Судалгааны талбайн байршил

“Барловорлд Монголиа” ХХК-ийн эзэмшлийн “0006411” тоот газар ашиглах гэрчилгээтэй “Засвар, үйлчилгээний төв” төслийн талбай нь засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт, сумын төвийн урд захад оршино. Улаанбаатар хотоос 650 км, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн хойш 250 км, сумын төвөөс баруун тийш 16 км зайтай.

Тус төсөл хэрэгжиж буй 0006411 тоот газар ашиглах эрхийн гэрчилгээтэй 3 га талбайг Өмнөговь аймгийн Ханбогд сумын засаг даргын 2008 оны 11 сарын 05-ны өдрийн 051 тоот шийдвэрээр эзэмшдэг.

Энэхүү хүнд машин механизмын засварын цехэд уул уурхай, барилга, зам засварын тоног төхөөрөмжийн оношилгоо, засвар үйлчилгээ, техникийг тос, тосолгоо, задлах, засварлах, угсрах үйл ажиллагааг явуулна. Мөн жижиг эд ангиудыг угааж тосноос цэвэрлэж задлах, угсрах зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

Засвар, техник үйлчилгээний хэсэгт 1 хоногт 2 машин, 7 хоногт 10 тээврийн хэрэгсэл болон хүнд машин механизмд хөдөлгүүрийн тос солих, явах эд ангийн засвар, хөдөлгүүрийн засвар, оношилгоо ба бусад үйлчилгээг үзүүлдэг.



Зураг 4. Төслийн талбайн байршил, сансрын зураг

Төслийн талбайн газар ашиглах гэрчилгээний солбицлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. 0006411 газар ашиглах гэрчилгээтэй талбайн солбицол

Дугаар	№	Уртраг			Өргөрөг			Талбай, м <sup>2</sup>
		град	мин	сек	град	мин	сек	

0006411	1	107	12	24.98	43	11	40.54	30016.29
	2	107	12	22.13	43	11	43.05	
	3	107	12	32.70	43	11	48.93	
	4	107	12	35.52	43	11	46.45	

### 2.1.2 Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл

Төслийн нутаг дэвсгэр нь эх газрын эрс тэс уур амьсгалтай ба урт, хүйтэн өвлийн болон богино халуун зуны улиралтай. Өвлийн хамгийн хүйтэн сар нь 11-р сараас 2-р сар хүртэл үргэлжилдэг ба агаарын дундаж температур  $-8^{\circ}\text{C}$  байдаг ба  $-40^{\circ}\text{C}$  хүрэх тохиолдол байдаг. 12-р сараас 2-р сарын хооронд маш бага хэмжээний буюу 3 см орчим зузаантай цасан бүрхүүл тогтдог.

Хаврын улирал 3-р сараас 5-р сарын хооронд үргэлжлэх ба энэ үед агаарын температур нэмэгдэх боловч чийг, хур тунадас багатай, салхины хурд харьцангуй их байдаг. Агаарын температур  $-1^{\circ}\text{C}$ -ээс  $+22^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэх ба агаарын харьцангуй чийгшил энэ үед 40% орчим байдаг. Хаврын улиралд шороон шуурга ихэсдэг тул түр хугацаагаар үйл ажиллагаа зогсох зэрэг хүндрэлүүд гардаг. Салхины хурд 5 м/с-ээс 34 м/с хүрдэг ба дундаж нь 5.5 м/с байдаг.

Зуны улирал 6-р сараас эхлэн 9-р сарын дунд үе хүртэл үргэлжлэх ба агаарын дундаж температур  $+22^{\circ}\text{C}$  орчим байх ба хамгийн өндөр температур  $+40^{\circ}\text{C}$  хүрдэг. Жилийн хур тунадасны дундаж хэмжээ маш бага (тухайлбал Ханбогд суманд жилд ердөө л 95 мм орчим байдаг) ба хур тунадасны ихэнх хэсэг зуны улиралд унадаг ба хамгийн их хур бороо 7-р сард ордог. Дунджаар, зуны улиралд 20 гаруй өдөр л хур бороотой байдаг.

Өмнийн Говьд намрын улирал Монгол улсын бусад бүс нутгийн намраас илүү дулаан, налгар болдог бөгөөд 9-р сараас 11-р сарын дунд үе хүртэл үргэлжилнэ. Агаарын дундаж температур  $-3^{\circ}\text{C}$ -ээс  $+16^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлздэг. Намрын улиралд агаарын даралт нэмэгддэг ба хур тунадасны хэмжээ багасдаг.

### 2.1.3 Геологийн тогтоц ба геоморфологи

Төслийн талбай нь Монгол орны өмнөд цөлийн бүсэд орших бөгөөд энэхүү бүс нь далайн түвшнээс дээш 1000 гаруй метрийн өндөрт өргөгдсөн нам, үргэлжилсэн дов толгодтой тал газар юм.

Геологийн тогтоц нь нимгэн зөөлөн шаварлаг хурдсаас Цэрдийн ба Дөрөвдөгчийн үеийн шавар болон элс, хайргаас тогтсон байдаг. Эдгээр хурдсууд нь эрдэс бүхий Палеозойн үеийн чулуулаг хурдсыг дээгүүр нь хучсан байдаг.

Талбайн Палеозойн үеийн геологийн тогтоц нь харьцангуй нийлмэл бүтэцтэй бөгөөд агуулагч чулуулаг нь бүтцийн шилжилт хөдөлгөөн, эрдэсжилт болон галт уулын дэлбэрэлтээс үүссэн янз бүрийн төрлүүдтэй холилдож үелэн тогтсон байдаг. Төслийн талбай нь эх газрын хөвөө болон галт уулын цуврал арлын Девонгоос Карбоний үеийн галт уулын болон тунамал чулуулгийн зүүнээс баруун чиглэлд тогтсон бүс дотор байрладаг ба Монголын өмнөд хэсгийн галт уулын бүс гэж нэршжээ.

Палеозойн мөчлөгийг дараах нэгжүүдэд хуваадаг.

- Уул нуруудын цувраа тогтоцын идэвхижилтэй туф, базальт болон тунамал чулуулгийн давхарга (Девоны үеийн Алагбаяны тогтоц)
- Конгломерат, далайн чулуулаг, элс, туф, базальт, андезит болон галт уулын чулуулаг зэргээс тогтсон үе давхаргууд (Карбоны үеийн Сайншанд худгийн тогтоц)

Энэхүү Палеозойн мөчлөгийн дээд хэсэг нь аажмаар өгөршсөн байдаг.\

#### **2.1.4 Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар**

Төслийн талбайн гидрогеологийн нөхцөлийг бичихдээ “Барловорлд Монголиа” ХХК-ийн Ажилчдын хотхон төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангийн гидрогеологийн хэсгээс ашиглав. Тус тайлангийн гидрогеологийн бүлгийг бичихдээ Өмнөговь аймгийн гидрогеологийн тулгуур бүтээлүүд болон Өмнөговь аймгийн Усны аж ахуйн байгууллага, судлаачдын 1974-2007 оны хооронд нийт 33 жилийн хугацаанд хийсэн гидрогеологи-геофизикийн тайланг ашигласан гэж өгүүлжээ.

Ханбогд сумын нутаг дэвсгэрт 1974-2007 оны хооронд гаргасан 30 гаруй цооногуудын гидрогеологийн үзүүлэлтүүдэд анализ хийж үзэхэд цооногийн дундаж гүн 96.5 м, уст үеийн дундаж интервал 55.9-87.1 м, уст үеийн дундаж зузаан 31.2 м, статистик дундаж түвшин 22.1 м, динамик дундаж түвшин 41.4 м, дундаж ундарга 2.2 л/с байна.

#### **2.1.5 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол**

##### **2.1.5.1 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал**

Судалгааны талбай болон түүний орчимд умард цөлийн цайвар бор хөрс тархсан байна. Говийн хялганат-таана-сөөгөнцөрт, үетэнт сөөгөнцөрт бүлгэмдэл хээршмэл цөлийн ургамалшил доор тогтворжих бөгөөд хөрсний гадарга дээрх ургамлын бүрхэц 8-15% байна. Энэ хэв шинжийн хөрс уур амьсгалын халуун, хуурай нөхцөлөөс хамааран хөрсний өнгөн хэсэг дээд үеүд хүчтэй халж, ургамлын үлдэгдэл эрдэсжих явц эрчимтэй байдгаас ялзмагт давхарга тод илрэхгүй. Давсны хүчилд гадаргаасаа эхэлж хүчтэй бургиж хөөсөрнө. Энэ хөрс гадаргаасаа эхлээд бүх үе давхарга нь карбонаттай байна.



Дээд үедээ ялзмагийн агууламж доод үе давхаргаасаа арай илүү байна. Энэ нь өнгөнөөсөө карбонатлаг шинжийн хөрс бөгөөд гадаргын 2см орчим зузаан нь элсэн хучаасаар хучигдсан байна. Дэд хэв шинжид нь хээржүү цөлийн бор хөрс зонхилсон байна.

Одоогоор техник ашиглалтын нөлөөлөлд өртөөгүй хөрс болно.



Зураг 5. Зүсэлт хийсэн талбайн орчны төрх болон хөрсний зүсэлтийн зураг

Хөрсний урвалын орчин 8.5-9.4 буюу бүх үе давхаргад шүлтлэг шинжтэй. Цахилгаан дамжуулах чадвар сул 0.11-1.21 байна. Хөрсний шинж чанарын гол үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ дээд үед 0,46% байхад доод давхаргад 0,27-0,19% буюу ялимгүй багасах хандлагатай байгаа нь ургамлын үндэсний хуваарилалттай холбоотой. Ялзмагийн бодисын найрлагад фульво хүчлийн хэмжээ ямагт илүү байх тул ялзмаг нь гумат-фульво шинжтэй. Хөрс нь байнга карбонатлаг байдгаас хамаарахгүйгээр ялзмагийн хүчлүүдийн найрлагад  $R_2O_3$ -ийн бүтэн хагас ислүүдтэй нэгдэл үүсгэдэг фракцын хэмжээ давамгайлж ялзмаг нь хөдөлгөөнт шинжтэй байна. Хөрсний шингээх багтаамжийн хэмжээ бага (100 гр хөрсөнд 16-12.9 мг-экв), солилцоот сууриудын найрлагад кальцийн ион давамгайлж байна. Хөрсний усан тунгаамлын химийн найрлагаас харахад хялбар уусах давсны агууламж бага 0.06-0.55%. Энэ нь умард цөлөрхөг нутгийн хөрсний онцлог шинж юм.

#### 2.1.5.2 Хөрсний бохирдолт

Судалгааны талбайд тус компанийн Засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай холбоотой хөрсний эвдрэлийн ул мөр төдийлөн их биш байна. Барилга байгууламж барьсантай холбоотойгоор хөрсөн бүрхэвч дарагдсан байна. Машин механизмын тос, масло хадгалалт болон солих үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөнд химийн болон механик бохирдлууд түгээмэл ажиглагдана.

Эзэмшил талбайн хөрс хүнд металлаар бохирдсон эсэхийг хөрсний өнгөн үе, давхаргуудаас авсан дээжид хийсэн бөгөөд хөрсний бохирдолтын дээжлэлтийн үр дүнг Монгол улсын стандарт хэмжээ (MNS 5850:2008)-тэй харьцуулан

дүгнэлээ. Шинжилгээний дүнгээс харахад Засвар үйлчилгээний төвийн хашаанаас авсан дээжид хийсэн хөрсний хүнд металлын шинжилгээгээр хүнд металлын агууламж стандарт хэмжээнээс даваагүй байна.

### 2.1.6 Ургамлан бүрхэвч

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалтаар хувьд Евразийн хээрийн их муж, Дорнод говийн цөлийн хээрийн тойргийн Ханбогдн районд хамрагддаг. Хойгуураа Ханбогд агаруутын цав толгодорхог өндөрлөгөөр хашигдсан Галбын уудам тал нутаг Хүрх уулсаас зүүн тийш байна. Хотгор гүдгэрийн зонхилох хэв шинж нь томоохон бэсрэг уулсуудтай хоршин тааралддаг нугачаа гүвээ бүхий хэвгий уудам тал газар юм.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Барловорлд Монголиа” ХХК-ийн Засвар үйлчилгээний төвийн нийт 3 га талбайн ургамлан нөмрөгт судалгаа хийж, төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийсэн. Ханбогд район нь цав толгод уулс зонхилсон харьцангуй үнэмлэхүй өндөр 1400-1700м нутаг юм.

Судалгааны талбай нь цөлийн хээрт 8 овгийн 15 төрлийн нийт 15 зүйл ургамал бүртгэгдсэн. Судалгааны талбайн эргэн тойронд ургамал нөмрөгт өөрчлөлт орсон. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь сор1, бусад зүйл ургамлууд нь sp-sol үнэлгээтэй байна. Ерөнхий тусгаг бүрхцийн ихэнх хувийг олон наст өвслөг ургамлууд бүрдүүлж, тэдгээрийн 2-р ташингын сөөгөнцөрлөг ургамлын хагд ба борог өвс бүрдүүлж байлаа. Ургамлын ташинга үүсгэх байдлаар нь үзвэл сөөг, сөөгөнцөр сөөгөнцөрлөг ургамал дээд дэд, олон наст өвслөг, ургамал дунд дээд, өнгөрсөн жилийн борог өвс, хагд (найлзуурууд) доод дэд ташингыг бүрдүүлж байна.

### 2.1.7 Амьтны аймаг

Өмнөговь аймаг Төв Азийн их говь цөлийн бүсэнд оршино. Төслийн талбай орчмын газар нутаг нь амьтны газарзүйн мужлалын хувьд Хойд говийн тойрогт хамаарна (А.Г.Банников 1954).

Төслийн талбай орчмын нутаг дэвсгэр нь амьтны аймгийн хувьд төдийлөн ядмаг биш ч төсөл хэрэгжиж буй талбай нь сумын төвд байрлах учир амьтад үргэн дайжиж, суурин газрын цөөн зүйл амьдрах ажээ.

### Сээр нуруугүй амьтан

Монгол орны Говийн шоргоолжнуудыг М. Пфайфер болон түүний хамтрагчид (2003, 2006) судалж, Монгол орны хэмжээнд тархсан шоргоолж нь ердөө 68 зүйлээс бүрддэг болохыг тогтоожээ. Тэд дүгнэхдээ хүйтэн өвлийн улирал нь шоргоолжны зүйлийн олон янз байдлыг хязгаарладаг хүчин зүйл байж болох бөгөөд халуун цөлийн 2 зүйл шоргоолж Говь нутагт өргөн тархсан байгаа нь

амьтны аймгийн зүйлийн олон янз байдал ядмаг байгааг харуулж байгаа бөгөөд их нь багийгаа барьж иддэг зарчмын жишээ байж болох юм гэжээ.

### **Хоёр нутагтан**

Монгол орны Говийн бүсээс болон төслийн талбайд оршдог цорын ганц хоёр нутагтан бол ОУБХХ-ны ангиллын дагуу Монголын Улаан дансанд (Тэрбиш ба бусад, 2006) анхааралд өртөхөөргүй гэж бүртгэсэн, Монгол бах (*Pseudepidalea raddei*) юм. Бах нь хавар эрт ичээнээс гарах үедээ Бор Овоо зэрэг тогтмол ундаргатай булаг шанд болон боржин массивын бэлээр орших булаг шандны орчимд үржилд ордог байна.

### **Мөлхөгчид**

Монгол орны өмнөд хэсгийн говь цөлд хатуу ширүүн улирлын нөхцөл болон хуурай болон хагас хуурай нөхцөлд дасан зохицсон хэдэн зүйлийн өргөн тархацтай гүрвэл болон могойны зүйлүүд тархсан байдаг. Төслийн талбай орчимд найман зүйлийн гүрвэл болон таван зүйлийн могой байдаг хэмээн тэмдэглэгдсэн байна.

Төслийн нөлөөллийн бүсд бүртгэгдсэн гүрвэл болон могойны зүйлүүдийн аль нь ч ОУБХХ-ны ангиллаар дэлхийн хэмжээнд ховордсон ангилалд буюу улсын хэмжээнд Монгол орны хэвлээр явагч болон хоёр нутагтны Улаан дансанд (Тэрбиш ба бусад, 2006) ховордсон хэмээх ангилалд багтаагүй байна.

Судалгааны талбай орчмын нутагт 11 зүйл мөлхөгчид байрших бөгөөд зүйл тус бүр өөр өөрийн амьдрах бичил орчинд тохиолдох онцлогтой. Эдгээрээс 1 зүйл (тэмээн сүүл могой) CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн, 2 зүйл нь ховордож болзошгүй, 2 зүйл улаан номд орсон амьтад бөгөөд бусад зүйлүүд өргөн тархацтай анхааралд өртөхөөргүй зүйлүүд юм.

### **Хөхтөн**

Төслийн талбай орчмын бүс нутаг нь жижиг хөхтөн (жишээлбэл, алагдаахай, чичүүл, багваахай, зараа), махчин амьтад (жишээлбэл, суусар, зэрлэг муур, үнэг, чоно) болон өмнө Говийн бүс нутагт нийтлэг тохиолддог томоохон өвсөн тэжээлтэн амьтдаар баян юм. Энэхүү бүс нь хулан (*Equus hemionus*) болон хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) зэрэг түүхэн тархац нутгийнхаа ихэнх хэсэгт устаж үгүй болсон дэлхийн хэмжээнд чухал популяцуудын гол амьдрах нутаг болж байна. Хад чулуу, уулархаг бүс нь янгир (*Capra sibirica*) болон аргалийн (*Ovis ammon*) амьдрах нутаг болж байдаг. Төслийн талбай нь сумын төвд учир эдгээр амьтдын ихэнх нь хүний хөл хөдөлгөөнөөс үргэн дайжжээ.

## Шувуу

Төслийн талбай орчмын нутаг дэвсгэрт 40 гаруй зүйлийн шувуу бүртгэгдсэн бөгөөд Оюу Толгойн төслийн биологичид энэхүү жагсаалтад байнга шинэ шинэ төрөл зүйлүүдийг нэмэн оруулсаар байгаа аж.


Монгол орон нь умард зүгт байрладаг, хатуу ширүүн өвлийн улиралтай байдгаас улбаалан өвөлждөг шувуудын төрөл зүйл цөөн байдаг.

### 2.1.8 Тусгай хамгаалалттай газар

Өмнөговь аймгийн хэмжээнд байгаа улсын тусгай хамгаалалттай газрууд нь нийт 3,490,894 га талбайг (нийт нутаг дэвсгэрийн 21.1%) хамардаг бөгөөд дараах газруудаас бүрдэнэ:

Хүснэгт 2. Өмнөговь аймаг дахь улсын тусгай хамгаалалттай газар нутгууд

№	Тусгай хамгаалалттай газар нутгууд	Нийт талбай (га)	Өмнөговь аймгийн нутагт хамаарах талбай (га)
1	Говийн Бага Дархан Цаазат Газар А ба Б хэсэг	1,839,176	1,291,927
2	Говь Гурван Сайхан Байгалийн Цогцолборт Газар	2,694,737	2,171,737
3	Загийн Ус Байгалийн Нөөц Газар	273,606	27,230
	<i>Нийт</i>	<i>4,807,519</i>	<i>3,490,894</i>



Зураг 6. Судалгааны талбай болон тусгай хамгаалалттай газар нутгийн байршил

Судалгааны талбай нь тусгай хамгаалалттай газар нутгаас хол зайтай оршдог. Хамгийн ойр орших тусгай хамгаалалттай газар нутаг нь талбайгаас баруун тийш 88 км-т “Говь гурван сайхан” байгалийн нөөц газар, зүүн хойш 135 км-т “Загийн-Ус” байгалийн нөөц газар юм.

### 3 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Засвар, техник үйлчилгээний хэсэгт 1 хоногт 1-3 машин, 7 хоногт 15-20 тээврийн хэрэгсэл болон хүнд машин механизмд хөдөлгүүрийн тос солих, явах эд ангийн засвар, хөдөлгүүрийн засвар, оношилгоо ба бусад үйлчилгээг үзүүлдэг.

Тус засвар, үйлчилгээний цех нь нийт 3485 м<sup>2</sup> талбайд төлөвлөгдсөн бөгөөд энд тоног төхөөрөмжийн оношилгоо, засвар үйлчилгээ, техникийн тос, тосолгоо, задлах, засварлах, угсрах үйл ажиллагаа явагдана. Засвар үйлчилгээний агуулахын 2 давхарт оффис, 1 давхарт хүнд даацын машин механизмын сэлбэг хэрэгсэл хадгалах агуулах, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байрлана.

“Эко Хайрхан консалтинг” ХХК-ийн мэргэжилтэн, экспертүүд хээрийн судалгааны ажлыг нөлөөллийн бүсийн дотор хийж гүйцэтгэв /Хээрийн судалгааны үр дүнг тус төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангаас үзнэ үү/.



Зураг 7. Судалгааны талбайн барилга, байгууламж

### Хүснэгт 3. Байгаль орчны шинжилгээ

№	Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд	Тийм	Үгүй
<b>Ландшафтын бүрдэл хэсэг болон усан орчин, химийн бодисын хэрэглээний нөлөөлөл</b>			
1	Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт	+	
2	Газар ашиглалтын өөрчлөлт	+	
3	Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх	+	
4	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх		+
5	Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх		+
6	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх	+	
7	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх		+
8	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх	+	
9	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх	+	
<b>Орчны бохирдол</b>			
10	Хөдөлгүүрийн хөргүүрийг солих үед хөргөгч шингэн алдагдах эсэх	+	
11	Дугуйны хаягдал үүсэх эсэх	+	
12	Ашигласан тосыг тусгай зориулалтын талбайд хадгалдаг эсэх		+
13	Ашигласан тосыг шатаадаг эсэх		+
14	Хаягдал тосны шүүлтүүрийг дахин ашигладаг эсэх		+
15	Дугуй, ашигласан тос, тосны шүүлтүүр гэм мэт хаягдлыг талбай дээр нь устгадаг эсэх		+
16	Аккумуляторын хаягдлыг талбайд дээр устгадаг эсэх		+
17	Аюултай шинжтэй хог хаягдлыг Монгол улсын Засгийн газрын 264-р тогтоолын дагуу ангилан ахуйн шинжтэй хог хаягдлаас тусад нь хадгалдаг эсэх		+
<b>Эрсдэлийн үнэлгээ</b>			
18	Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл	+	
19	Байгаль орчинд үүсэх эрсдэл	+	

## 4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

### Байгаль орчин-эдийн засаг

Энэхүү төслийн үйл ажиллагаа нь МУ-ын ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Бүс нутгийг хөгжүүлэх бодлого, засаг захиргааны нэгжийн хөгжлийн хөтөлбөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт тусгагдсан үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулна. Улс орны эдийн засагт дараах хэлбэрээр хувь нэмэр оруулна.

- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- Нийгмийн л шимтгэл
- Газар ашигласны төлбөр
- Ус ашигласны төлбөр
- Байгалийн нөөц баялаг ашиглахтай холбогдох татвар, төлбөрүүд

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба ОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжинэ.

### Байгаль орчин-удирдлага зохион байгуулалт

Төсөл хэрэгжүүлэгч “Барловорлд Монголиа” ХХК нь байгаль орчны мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллана. Ингэснээр байгаль орчны календарьчилсан төлөвлөгөө гаргаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

### Байгаль орчны бодлого, зорилго

“Барловорлд Монголиа” ХХК нь экологи-эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх байгаль орчны бодлогоо дараах хэлбэрээр тодорхойлсон.

- Компанийн бүхий л үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах асуудал нь чухал ач холбогдолтой байна.
- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх, байгаль орчны үзүүлэлтүүдийг сайжруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд учруулах нөлөөллүүдийг хүрч болох хамгийн бага түвшинд байлгах аар хянана.
- Компанийн байгаль орчны бодлого, зорилт, хэрэгжилт, тэдгээрийн үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байна.



#### 4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Бохир ус	Бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж рүү орж байгаа ус болон цэвэршүүлээд гарч байгаа уснаас дээж авч шинжлүүлэх	Бохир ус, цэвэршүүлсэн бохир ус	ш	2	126	252	3-р улирал	Усны тухай хууль MNS 4943:2015 MNS 6148:2010
	Дээрх шинжилгээний дүнг MNS 4943:2015 стандарттай харьцуулж цэвэрлэх чадварыг дүгнэх	Бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж	-	-	-	-	3-р улирал	
Хөрс, ургамал бохирдох, нэвчилт явагдах	Хог хаягдал түр хадгалах цэгийн доорх талбайг нэвчилт, шүүрэлт явагдахааргүй хатуу хучилттай болгох	Газрын доорх ус, хөрсний чанар	м <sup>2</sup>	50	5	50	2-р улирал	Хог хаягдлын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Хөрс, ургамлан нөмрөг талхлагдах	Техник хэрэгслийн засвар, тос солих үйлчилгээг зөвхөн хатуу хучилттай талбайд хийх	Засварын газар	-	-	-	-	Тогтмол	MNS 5850:2019
Хөрс, ургамлан нөмрөг талхлагдах	Гадаад тээврийн зам буюу Нарийн сухайтын замаас засварын төв хүртэлх 2 км урттай шороон замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	2.3км шороон зам	ш	50	2	100	3-р улирал	MNS 4597:2014

Шатах тослох материалаар хөрс бохирдох	Шатах тослох материал хөрсөнд алдагдсан нөхцөлд шингээх материал бэлэн байлгах	Хөрс хамгаалал	иж бүрдэл	1	-	5000	Тогтмол	MNS 5850:2019
Хаягдал дугуйнаас хөрс бохирдох	Аюулгүй ажиллагаанд сэргээр нөлөөлөхөөргүй бол “РеМаТирТор” ХХК-иар дахин хээ гаргуулж хүнд даацын техникийн дугуйны ашиглалтыг уртасгах (run out)	Хөрсөн бүрхэвч	Хаягдал дугуй	-	-	-	Шаардлагатай үед	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай
Хөрс бохирдох	Дизель генератор, аюултай хог хаягдал түр хадгалах цэгийн доорх талбайд асгаралт явагдсан тохиолдолд талбайн хөрсийг цэвэрлэх, саармагжуулах (Хими, хими технологийн хүрээлэн гэх мэт мэргэжлийн байгууллагатай хамтран)	Бохирдсон хөрсийг хуулах	м <sup>3</sup>	-	-	3000	Тухай бүрд	MNS 5850:2019
<b>Нийт, мян.төг</b>						<b>8402</b>		

#### 4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	50 ш мод тарих	Өөрийн эзэмшил талбайд	ш	50	30	1500.0	5, 10 сар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
2	- Эзэмшил талбайн 10%-аас доошгүй талбайд ногоон байгууламж бий болгох	50 ш мод тарих, тарьсан мод, сөөгийг арчилж ургуулах, зүлэгжүүлэх		ш	50	30	1500.0	5, 10 сар	
3	Нийт, мян.төг						<b>3000.0</b>		

### 4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Энгийн хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах - Төмрийн хаягдал - Цаасны хог хаягдал - Гялгар уутны хаягдал - Хуванцар хаягдал - Ерөнхий хаягдал - Модны хаягдал - Хоол хүнсний хаягдал - Шил, лааз, ундааны сав г.м	Бүх хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
Энгийн хог хаягдал	Шаардлагатай газруудад доорх цаас, хуванцар сав, тостой хаягдал, бусад г.м ангилал бүхий хогийн савнууд байрлуулах	Засварын газар, ажилчдын байр	ш	250.0	2	500	3-р улирал	Хог хаягдлын тухай хууль
	Энгийн хог хаягдлыг сумын ТҮК-ээр зайлуулах /гэрээ сунгах/	Хөрс бохирдох	тн	-	-	Гэрээний дагуу	Сард 1-2 удаа	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011
	Ахуйн хатуу хог хаягдлыг түр хадгалах битүүмжлэл сайтай, ангилан ялгалт хийж хадгалах боломжтой бункер суурилуулах		ш	1	150	150	-	Хог хаягдлын тухай хууль
	Ахуйн хог хаягдлын бункерт	Хог хаягдал	ш	1	-	-	2022	Хог хаягдлын

	анхааруулга тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	ангиалан хаях						тухай хууль
Аюултай хог хаягдал	Хаягдал тос, тосолгооны материалын хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах - Тостой даавуу - Тостой сав, баглаа боодол - Шатах тослох материалын хаягдал - Тосны шүүр - Хаягдал батарей - Аккумулятор г.м	Аюултай хог хаягдал	бүх	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль Засгийн газрын 116-р тогтоол
	Ашигласан тос, тосолгооны материал, тостой даавуу гэх мэт аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Хөрс бохирдуулах	-	-	-	Цэцүүх трейд ХХК-тай байгуулсан гэрээний дагуу	Тогтмол	
	Хаягдал аккумуляторыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах	Хаягдал аккумулятор	ш	Үлэмж хүдэр ХХК-д			Жил бүр	
	Хаягдал дугуйг 2-догч түүхий эд авах цэгт тушаах, тушаах боломжгүйг холбогдох журмын шаардлага хангасан нөхцөлд өөрийн талбайд түр хадгалах	Хаягдал дугуй		Жижиг дугуйг “Инахис” ХХК-д нийлүүлэх, том хэмжээтэйг өөрийн талбайд хадгалах			Жил бүр	
	Хаягдал батарейг өөрийн талбайд хадгалах	Бүх батарей	ш	-	-	Өөрийн талбайд түр хадгалах	Тогтмол	

	Ашигласан тос түр хуримтлуулах битүүмжлэл сайтай, агааржуулалтын систем бүхий сав байрлуулах	0.7 м <sup>3</sup> багтаамжтай	ш	2		700	2-р улирал	
<b>Нийт, мян.төг</b>						<b>1350</b>		

#### 4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “**орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**” гэнэ.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар	<b>Тоосонцор:</b> TSP, PM2.5, PM10 SOx NOx COx Дуу шуугиан	- Засварын газрын хашаан дотор - Засварын газар - Ажилчдын байр	Жилд 1 удаа	-	85	MNS 4585:2016 Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
Хөрсөн бүрхэвч	- Агрехими - Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../ - Нефтийн бүтээгдэхүүн - Бактереологи	- Хаягдал тос хадгалах талбай - Хогийн цэг	Жилд 1 удаа	55.0	110.0	MNS 5850:2008 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Ус	- Хүнд металл - Анион, катион - Бактереологи	- Худгийн ус	Жилд 1 удаа	46	46	MNS 4943:2015 MNS 900:2018 Усны тухай хууль
<b>Нийт зардал, мян.төг</b>					<b>241.0</b>	

#### 4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Тухайн жилийн БОМТ-г БОАЖЯ-р батлуулах	-	1-р улирал	БО-ы мэргэжилтэн	БОНБУ-ий тухай хууль
2	Ус ашиглуулах дүгнэлтийг аймгийн байгаль орчны газраар гаргуулах	50	2-р улирал	БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
3	Сумын ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ байгуулах, эрхийн бичиг авах	-	2-р улирал	Захирал	Усны тухай хууль
6	Нийт зардал, мян.төг	50.0			



#### 4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс БО болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тухай	10 сар	50.0	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Ханбогд сум, ИНХ
2	БОМТ-ий биелэлтийн тайланг аймгийн БО-ы газраар дүгнүүлэх	3% хэвлэмэл болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай	11 дүгээр сарын 1	-	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Өмнөговь аймгийн БОАЖГ
3	Нийт зардал, мян.төг				50.0		

*Хүснэгт 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал*

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	8402.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	3000.0
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1350.0
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	50.0
5	Орчны хяналт шинжилгээ	241.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	50.0
<b>Нийт зардал, мян.төг</b>		<b>13 083.0</b>

## 5 ДҮГНЭЛТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Хүнд даацын машин механизмын засварын төв” төслийн 2024 оны орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 13.083 мян.төг болно.